

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ЭМИЙН АШИГТ УРГАМЛЫН ТАРХАЦ, НӨӨЦИЙН СУДАЛГААНЫ ДҮН

3.1. Сүхбаатар аймгийн хэмжээнд эмийн ашигт ургамлын биологийн нөөцийн зэрэглэл тооцсон дүн

Сүхбаатар аймгийн эмийн ашигт ургамлын нөөцийн зэрэглэл тогтоосон шатлал:

1. Эмийн ашигт ургамлын биологийн ургац 2 ц/га –аас бага бол **нөөцгүй**,
2. Эмийн ашигт ургамлын биологийн ургац 2.1-3.9 ц/га бол **бага нөөцтэй**,
3. Эмийн ашигт ургамлын биологийн ургац ургац 4.0-4.9 ц/га бол **Дундаас доогуур нөөцтэй**,
4. Эмийн ашигт ургамлын биологийн ургац ургац 5.0-5.9 ц/га бол **Дунд зэргийн нөөцтэй**,
5. Эмийн ашигт ургамлын биологийн ургац ургац 6.0-6.9 ц/га бол **Дундаас дээгүүр нөөцтэй**,
6. Эмийн ашигт ургамлын биологийн ургац ургац 7.0 ц/га –аас дээш бол **их нөөцтэй** гэж тооцсон (Орхон аймагт) аргачлалын дагуу бодоход эмийн ашигт ургамлын биологийн ургац 2 ц/га –аас бүгд бага тул ашиглах нөөцгүй нь тогтоогдлоо.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 1573725 (аймгийн бэлчээрийн 19.0%) га талбайд эмийн ашигт ургамал маш таруу тархсан, малын бэлчээрлэлтээс болж ашиглах нөөцгүй болсон байна.

Хүснэгт 52. Сүхбаатар аймгийн хэмжээнд ургамалжлын тархац, нөөц, сумдаар

№	Сумын нэр	Талбай, га	Ашигт ургамлын нэр	Нөөцийн зэрэглэл	Биологийн нөөц, ц	Биологийн нөөц, ц/га
1	Эрдэнэцагаан	792070	Урал чихэр өвс, Дэрэвгэр жиргэрүү Алаг бэрмэг Нягт сонгино	Нөөцгүй	18009	0.02
2	Сүхбаатар	157263	Ганц үрт зээргэнэ, Урал чихэр өвс, Анхил сонгино, Шар бэрмэг	Нөөцгүй	55595.5	0.35
3	Дарьганга	221291.6	Цагаан навчит хасзул <i>Ломоносовын</i> хасзул Нягт сонгино,	Нөөцгүй	36658.61	0.17

			Дэрэвгэр жиргэрүү			
4	Асгат	18441.2	Урал чихэр өвс Нарийн цахилдаг	Нөөцгүй	12950.02	0.7
5	Наран	12680.2	Цулбуур цахилдаг, Шар бэрмэг	Нөөцгүй	760.08	0.06
7	Онгон	42059.1	Шар бэрмэг	Нөөцгүй	462.7	0.01
8	Халзан	114239	Цулбуур цахилдаг Шар бэрмэг	Нөөцгүй	1615.1	0.014
9	Баяндэлгэр	67456.7	Цулбуур цахилдаг Шар бэрмэг	Нөөцгүй	1008.8	0.015
10	Уулбаян	66733.6	Цулбуур цахилдаг, Шар бэрмэг	Нөөцгүй	1241.5	0.019
11	Мөнххаан	18341.3		Нөөцгүй	14775.05	0.8
12	Түмэнцогт	20312.8	Урал чихэр өвс	Нөөцгүй	9140.76	0.45
13	Түвшинширээ	42836	Цулбуур цахилдаг, Шар бэрмэг	Нөөцгүй	706.4	0.02
	Нийт	1573725			152923.5	

3.2. Эмийн ашигт ургамлын тархац, нөөц

3.2.1. *Ephedra monosperma* G. G. Gmel. Ex C. A. Mey.-Ганц үрт зээргэнэ



Зураг 32. *Ephedra monosperma*
G. G. Gmel. Ex C. A. Mey.

Статус: Элбэг, эмийн ашигт ургамал

Биологийн онцлог: Газар дор мөлхөө найлзууртай, 3-20 см намхан нэлэмгэр ургадаг, шар ногоон нарийхан ширүүвтэр мөчиртэй, нэг үртэй улаан жимсгэнэ жимстэй. **Амьдралын хэлбэр:** Дэлхээ сөөгөнцөр ургамал.

Монгол дахь тархалт: Хөвс., Хэнт., Ханг., Монг. –Даг., Монг. -Алт, Ховд., Дунд Халх., Их н., Олон н., Говь –Алт., Дон. Говь, Зүүнгар.

Ургах орчин: Хайргархаг хажуу бэлээр ургана.

Ашигт чанар: Малын идвэл хортой. Ногоон мөчир, найлзуур, үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

Сүхбаатар аймаг дахь тархац: Сүхбаатар сумын нийт 65081.3га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Сүхбаатар сумын хэмжээнд 16270.33 ц буюу 162 тонн биологийн нөөцтэй бөгөөд ургамлын тархалтаас хамаарч нэг га талбайд 0.20-0.25 центнер биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 53. Сүхбаатар аймгийн хэмжээнд Ганц үрт зээргэний тархац, нөөц

I D	цэг	Тархац	Талбай, га	Газрын дээрх биомасс 1м ² /гр	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
15	8, 26	Сүхбаатар суман дахь Үетэн-агь-алаг өвс-шарилжит, зээргэнэт	65081.3	2.5	0.25	16270.33
Нийт, га			65081.3			

3.2.2. *Glycyrrhiza uralensis* Fisch.-Урал чихэр өвс



Статус: Ховор ургамал

Биологийн онцлог: Иш эгц босоо мөчирлөг бус, 40-100 см өндөр, навчис 4-8 хос, өндгөрхүү зуувгар, цавуулаг булчирхайтай, цэцэг том, цайбар нил, богинохон цацаг үүсгэнэ, буурцаг том хавчгар, мушгирч тахийсан.

Зураг 33. *Glycyrrhiza uralensis* Fisch.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.

Монгол дахь тархалт: Ханг., Монг.-Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Зүүнгар., Алт. өвөр., Алаш.

Ургах орчин: Чийглэг марцлаг нуга, марц, хужиртай элс, элсэрхэг хээр, нуур, голын хөндийд ургана.

Ашигт чанар: Ногоон үед нь тэмээ сайн, хонь, ямаа дунд зэрэг иддэг. Эмийн гоц ашигт ургамал.

Сүхбаатар аймаг дахь тархац: Эрдэнэцагаан суманд 9212.7 га, Сүхбаатар суманд нийт 40201.1га, Асгат суманд 15100.5 га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Эрдэнэцагаан суманд 8107.176 цн, Сүхбаатар суманд 37789.03 цн, Асгат суманд 12835.43 цн, Түмэнцогт суманд 9140.76 цн, Мөнххаан суманд 4380.7 цн, аймгийн хэмжээнд нийт **90105 га талбайд** 72.25 тонн биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 54. Сүхбаатар аймгийн хэмжээнд Урал чихэр өвсний тархац, нөөц

ID	Цэг	Бэлчээрийн төрөл	Талбай, га	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц/га
Эрдэнэцагаан сум, 20	29	Хялгана-хиагт, Ерхөг-хиаг-хялганат	9212.7	0.88	8107.176
Сүхбаатар сум, 16	6, 19, 25	Хялгана-жижиг дэгнүүлт үетэн, Хялгана-хиаг-агь-алаг өвс-буурцагтант, Ерхөг-үетэн-буурцагтан-алаг	40201.1	0.94	37789.03

		өвст			
Асгат сум, 16	47	Хялгана-жижиг дэгнүүлт үетэн, Хялгана-хиаг-агь-алаг өвс-буурцагтант, Ерхөг- үетэн-буурцагтан-алаг өвст	15100.5	0.85	12835.43
Түмэнцогт сум, 99	16	Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт, Хялгана-хиаг-шарилжит	20312.8	0.45	9140.76
Мөнхаан сум, 100	16	Хялгана-жижиг дэгнүүлт үетэн, Хялгана-хиаг-агь-алаг өвс-буурцагтант, Ерхөг- үетэн-буурцагтан-алаг өвст	5277.9	0.83	4380.7
Нийт, га			90105		72253.1

4.2.3. *Saposhnikovia divaricata* (Turcz.) Schischk. - Дэрэвгэр жиргэрүү



Зураг 34. *Saposhnikovia divaricata* (Turcz.) Schischk.

Дунд. Халх., Дорн-Монг.

Ургах орчин: Хээржүү хажуу, хялганат хээр, уулын хээрээр, тариан талбайд ургана.

Ашигт чанар: Үндэсийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

Сүхбаатар аймаг дахь тархац: Эрдэнэцагаан сумын **2774.2** га, Дарьганга суманд 61711.6 талбайд тархацтай.

Статус: Ховор ургамал

Биологийн онцлог: Дэрэвгэр том, зэгэлдүү ногоон хатуу ургамал. Иш ганц, 30-80 см өндөр. Үндэс орчмын навчис богино бариултай, хөвөө дүрс гонзгой, хошоод гурвантаа өдлөг цуулбар, үр жимс өндгөрхүү, хурц гүргэр хавиргатай. **Амьдралын хэлбэр:**

Олон наст өвслөг ургамал. **Тархалт:** Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг.,

Нөөц тооцсон дүн: Сүхбаатар аймгийн хэмжээнд **2099.7** центнер биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 55. Сүхбаатар аймгийн хэмжээнд Дэрэвгэр жиргэрүүн тархац, нөөц

ИД	цэг	Тархац	Талбай, га	10 м ² талбай дахь бутны тоо	Газрын дээрх биомасс 1 бут/гр	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
22	32	Эрдэнэцагаан, Биелэг-хялгана-алаг өвс-агьт	2774.2	7	25.5	0.1785	495.2
27	40	Дарьганга, Жижиг дэгнүүлт хялгана-алаг хялгана-агьт	61711.6	1	26.0	0.026	1604.5
Нийт, га			64485.8				2099.7

4.2.4. *Limonium bicolor* (Vge.) Kuntze- Алаг бэрмэг



Зураг 35. *Limonium bicolor* (Vge.) Kuntze.

Статус: Элбэг ургамал

Биологийн онцлог: 15-30 см өндөр ургадаг, сууриаса салаалсан, гонзгой тонгоруу өндгөрхүү, баг цэцэг, цоморлиг хурц улаанаас цайвар ягаан, цагаан, дэлбэ шар юмуу өнгөгүй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.

Монгол дахь тархалт: Ховд, Дунд. Халх., Дорн. монг., Олон н., Дорн. говь. **Ургах орчин:** Элсэрхэг хээр, зүр өвст хээр, марцтай давстай

нуурын эргээр ургана.

Ашигт чанар: Цэцгийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

Сүхбаатар аймаг дахь тархац: Эрдэнэцагаан сумын нийт **11333.1** га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Эрдэнэцагаан сумын хэмжээнд 679.9 центнер биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 56. Сүхбаатар аймгийн хэмжээнд Алаг бэрмэгийн тархац, нөөц

ИД	цэг	Тархац	Талбай, га	10 м ² талбай дахь бутны тоо	Газрын дээрх биомасс 1 бут/гр	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
24	36	Эрдэнэцагаан, Хялгана-хиаг-шарилж-бэрмэгт, дэрс-жижиг улалжит,	11333.1	8	7.5	0.06	679.9
Нийт, га			11333.1				

4.2.5. *Olgaea leucophylla* (Turch.) Pjin -Цагаан навчит хасзул



Зураг 36. *Olgaea leucophylla* (Turch.) Pjin.

Статус: Нэн ховор ургамал

Биологийн онцлог: Голлосон бүдүүн үндэстэй, бүхэлдээ үсэрхэг, иш 50 см хүртэл өндөр, цагаан эсгийлэг үслэгтэй, үл мэдэг далавчтай, навч өдлөг хагалбар юмуу өдлөг ухалбар, дээд гадаргуу цайвар ногоон, сийрэг үслэгтэй, доод гадаргуу эсгийрхэг үслэгтэй, навчны салбангууд үзүүртээ өргөстэй, сагс том, ягаан өнгийн олон цэцэгтэй, ороолт орооцолдсон цагаан үслэгтэй, гаднах навчинцарууд өргөстэй,

цайвар ширүүн өргөсөрхүү цомцогтой. Үр хар бараан том. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал. **Тархалт:** Дунд. Халх., Дорн. Монг., Олон н., Дорн. говь., Говь – Алт. **Ургах орчин:** Элсэрхэг тэгш тал, цөлөрхөг хээрийн чулуурхаг хайргархаг хажуугаар ургана. **Ашигт чанар:** Идэмж тодорхойгүй. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.


Сүхбаатар аймаг дахь тархац: Дарьганга сумын нийт 34710.7 га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Дарьганга сумын хэмжээнд **2464.825** центнер биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 57. Сүхбаатар аймгийн хэмжээнд **Цагаан навчит хасзулын** тархац, нөөц

ID	цэг	Тархац	Талбай, га	10 м ² талбай дахь бутны тоо	Газрын дээрх биомасс 1 бут/гр	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, цн
40	44	Дарьганга, Суль-хиаг-алаг өвс-шарилжит, Суль-алаг өвс-агь шарилжит, харгана-үетэнт	27238.4	3	25.5	0.0765	2083.738
41	52	Үетэн-алаг өвс-агьт, Цагаан бургаст, хиагт	7472.3	2	25.5	0.051	381.0873
Нийт, га			34710.7				2464.825

4.2.6. *Olgaea Lomonosovii* (Trautv.) Iljin.-Ломоносовын хасзул



Зураг 37. *Olgaea Lomonosovii* (Trautv.) Iljin.

Статус: Ховор ургамал

Голлосон бүдүүн үндэстэй, бүхэлдээ үсэрхэг, иш 50 см хүртэл өндөр, цагаан эсгийлэг үслэгтэй, навч өдлөг хагалбар юмуу өдлөг ухалбар, дээд гадаргуу хар ногоон, нүцгэн гялгаар, ирмэгээрээ сормуулаг өргөслөг, 3 мм урт өргөсөнцөртэй, иш угаадаа нарийссан, ишээ нарийхан богино дагасан, сагс том, ягаан өнгийн олон цэцэгтэй, ороолт орооцолдсон цагаан үслэгтэй, гаднах навчинцарууд өргөстэй, цайвар ширүүн өргөсөрхүү

цомцогтой. Үр хар бараан том. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал.

Тархалт: Дорн. Монг. Даригангад байна. **Ургах орчин:** Элсэрхэг хэзээрээ ургана.

Ашигт чанар: Идэмж тодорхойгүй. Газар дээрх биеийг Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

Сүхбаатар аймаг дахь тархац: Дарьганга сумын нийт 103587.7 га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Дарьганга сумын хэмжээнд **32184.93** центнер биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 58. Сүхбаатар аймгийн хэмжээнд *Ломоносовын* хасзул тархац, нөөц

ID	цэг	Тархац	Талбай, га	10 м ² талбай дахь бутны тоо	Газрын дээрх биомасс 1 бут/гр	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
26	40, 41	Дарьганга, Хялгана-жижиг дэгнүүлт үетэнт	41876.1	15	23.5	0.353	14782.26
27	38	Дарьганга, Жижиг дэгнүүлт үетэнт-хялгана-алаг өвст, хялгана-агьт	61711.6	12	23.5	0.282	17402.67
Нийт, га			103587.7				32184.93

4.2.7. *Iris tenuifolia* Pall.-Нарийн цахилдаг



Зураг 38. *Iris tenuifolia* Pall.

Статус: Эмийн ашигт ургамал

Биологийн онцлог: Иш, найлзуурын уг навчны угларгын хүрэн ширхэглэгээр хучигдмал, үндэс орчимдоо 30-40 см урт утсархуу навчтай, жижиг дэгнүүлтэй, богино сум иштэй, цайвар хөх өнгийн 2 цэцэгтэй. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал.

Монгол дахь тархалт: Монг.-Алт., Дунд.Халх.,

Дорн. Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт., Зүүнгар. **Ургах орчин:** Элсэрхэг бай хайргархаг цөлөрхөг хэрээр ургана. **Ашигт чанар:** Хонь, ямаа хавар сайн иддэг, үхэр, тэмээ иддэггүй. Үндэс, цэцэг, үрийг эмэнд хэрэглэнэ.

Сүхбаатар аймаг дахь тархац: Асгат суманд 3340.7 га, Баяндэлгэр суманд 12905.3 га, Уулбаян суманд 44159.8га, Түвшинширээ суманд 16094.27 га, Халзан суманд 95906.2 га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Сүхбаатар аймгийн хэмжээнд **184908.9 га талбайд 184908.9** центнер буюу 1849 тонн биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 59.Сүхбаатар аймгийн хэмжээнд Цулбуур цахилдагын тархац, нөөц

ИД	цэг	Тархац	Талбай, га	10 м ² талбай дахь бутны тоо	Газрын дээрх биомасс 1 бут/гр	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
12	49	Асгат, Хялгана-алаг өвс-шарилжит	3340.7	7	4.9	0.0343	114.9
61	69	Баяндэлгэр, Агь-шаваг-монгол өвст	12905.3	3	4.5	0.0135	174.2
3	73	Уулбаян, Хазаар өвс-үетэн-алаг өвст	44159.8	3	4.6	0.0138	609.4
32	84	Түвшинширээ, Хиаг-хазаар-шарилжит	16094.2	2	5.0	0.01	160.9
13	50	Халзан, Хялгана-жиг дэгнүүл үетэн, Хялгана-хиаг-агь-алаг өвс-буурцагтант	95906.2	3	4.9	0.0147	1409.8
27	85, 87, 88	Мөнхаан сум, Хялгана-хазаар, хазаар-хялганат	12502.7			0.8	100002
Нийт, га			184908.9				102471.2

4.2.8. *Limonium aureum* (L.) Hill ex Ktze.-Алтан бэрмэг

Статус: Нэн ховор, эмийн ашигт ургамал



Зураг 39. *Limonium aureum* (L.) Hill ex Ktze.

Биологийн онцлог: 5-20 см өндөр ургадаг, сууриасаа их салаалсан, тахиралдсан, дэвсмэл иштэй, суурьтаа навчны бараан хүрэн үлдэгдлээр хучигдсан, үндэсний холтос хар хүрэн, цэцэг хурц алтлаг шар. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал. **Монгол дахь тархалт:** Ховд., Дунд. Халх., Дорн.-Монг., Их н., Олон н., Дорн. говь., Говь-Алт., Алт. -өвөр., Алаш.. **Ургах орчин:** Цөлөрхөг хээрийн үйрмэг чулуут хажуу, бэл хормой, марзлаг цөл, голын эргийн хужир,

марцтай хуурай элс, хайрга, тойрмын захаар ургана. **Ашигт чанар:** Бог мал зун, намар дунд зэрэг иддэг. Цэцгийн Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ.

Сүхбаатар аймаг дахь тархац: Сүхбаатар суманд 11779.0га, Түвшинширээ Уулбаян суманд 22573.8 га, Түвшинширээ суманд 26742.1 га, Халзан суманд 18332.8 га, Баяндэлгэр суманд 54551.4га, Наран суманд 12680.2 га Онгон суманд 42059.1 га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Сүхбаатар сумын хэмжээнд нийт 188718.4 га талбайд тархацтай, **3689.98**центнер биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 60. Сүхбаатар аймгийн хэмжээнд Шар бэрмэгийн тархац, нөөц

ID	Тархац	Талбай, га	10 м ² талбай дахь бутны тоо	Газрын дээрх биомасс 1 бут/гр	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
82	Сүхбаатар Дэрс-бударганат	11779.0	4	5.3	0.0212	249.7

83	Уулбаян, Бударгана -дэрст	22573.8	5	5.6	0.028	632.1
83	Түвшинширээ, Бударгана -дэрст	26742.1	4	5.1	0.0204	545.5
83	Халзан, Бударгана -дэрст	18332.8	2	5.6	0.0112	205.3
83	Баяндэлгэр, Бударгана -дэрст	54551.4	3	5.1	0.0153	834.6
83, 86	Наран, Бударгана –дэрст, бударганат	12680.2	4	6.5	0.026	760.08
83, 86	Онгон, Бударгана –дэрст, бударганат	42059.1	4	5.5	0.011	462.7
Нийт, га		188718.4				3689.98

4.2.9. *Allium condensatum* Turcz.- Нягт сонгино



Зураг 40. *Allium condensatum* Turcz.

Статус: Хүнс-тэжээлийн ашигт ургамал

Биологийн онцлог: Навчис голдоо хөндий, 4-7, шүхэр маш нягт бөөрөнхий, цэцэг цайвар шар, дохиур шадар эрхтэнээсээ цухуйсан, сонгинолог булцуу гонзгой шовгор, гадаад дотоод бүрхүүл гялгар хүрэн,
Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал.

Монгол дахь тархалт: Хянг., :Дунд. Халх., Дон. Монг.

Ургах орчин: Үетэн-алаг өвст

хээрээр ургана.

Ашигт чанар: Хүнс-тэжээлийн ургамал.

Сүхбаатар аймаг дахь тархац: Эрдэнэцагаан суманд 768749.7га, Дарьганга суманд 21281.6 га, талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Сүхбаатар аймгийн хэмжээнд нийт 790031.3 талбайд 18239.34 центнер биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 61.Сүхбаатар аймгийн хэмжээнд Нягт сонгинын тархац, нөөц

ID	Тархац	Талбай, га	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
13	Эрдэнэцагаан, Хялгана-алаг өвст, Хялгана-жигжиг дэгнүүлт үетэнт, Хялгана-хазаар өвст, 30, 31	768749.7	0.0232	17834.99
13	Дарьганга, Хялгана-алаг өвст, Хялгана-жигжиг дэгнүүлт үетэнт, Хялгана-хазаар өвст	21281.6	0.0190	404.35
Нийт, га		790031.3		18239.34

4.2.10. *Allium odorum* L.-Анхил сонгино



Зураг 41. *Allium odorum* L.-Анхил сонгино

Их н., Олон н., Дорн. говь., Говь –Алт.

Ургах орчин: Хээржүү хужирлаг нуга, хуурай хажууд ургана. **Ашигт чанар:** Хүнс тэжээлийн ургамал.

Сүхбаатар аймаг дахь тархац: Сүхбаатар суманд **40201.1** га тархацтай.

Нөөц тооцсон дүн: Сүхбаатар аймгийн хэмжээнд нийт **40201.1** талбайд **1286.4**центнер биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 62.Сүхбаатар аймгийн хэмжээнд Анхил сонгинын тархац, нөөц

ID	Тархац	Талбай, га	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
16	Хялгана-жигжиг дэгнүүлт үетэн, Хялгана-хиаг-агь-алаг өвс-буурцагтант, Ерхөг-үетэн-буурцагтан-алаг өвст	40201.1	0.032	1286.4
Нийт, га		40201.1		1286.4

4.2.11. *Polygonatum odoratum* (Mill.) Druce.-Анхилуун мухар цагаан



Зураг 42. *Polygonatum odoratum* (Mill.) Druce.

Статус: Элбэг

Биологийн онцлог: Үелсэн махлаг том үндэслэг иштэй. Иш 20 -70 см өндөр, өндиймөл юмуу нумраа. Навч өргөн гонзгой зууван, хоёр тал руугаа шувтан, ишээ зуусан, нүцгэн. Навчны өврөөс гарсан шилбэн дээр 1-2 хонхон цагаан цэцэгтэй. **Амьдралын хэлбэр:** Олон наст өвслөг ургамал. **Монгол дахь тархалт:** Хөвс., Хэнт., Ханг., Монг.-Даг., Хянг., Дунд. Халх., Дорн. Монг. **Ургах орчин:**

Шинэсэн ойд ургана. **Ашигт чанар:** Үндэслэг ишийг хэрэглэнэ. Флавноид, сапонин, кальцийн оксалат, гликозид, каротин, тиамин, витамин С болон ацетидин-2 карбонын хүчил агуулагдана. Мөгөөрсөн хоолойн үрэвсэл, уушигны хатгалгаа болон биеийн ядаргаа засахад хэрэглэдэг. Уламжлалт эмийн жоронд ордог. Мөн үндсийг нас уртасгах, хөгшрөлтийг удаашруулах, бэлгийн сулрал, бадгана, шар өвчин зэрэгт хэрэглэнэ.

Сүхбаатар аймаг дахь тархац: Мөнхаан сумын Мөнххаан ууланд нийт **560.7** га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Сүхбаатар аймгийн хэмжээнд зөвхөн Мөнхаан суманд Анхилуун мухар цагаан нийт **560.7 га талбайд 112** цн биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 63. Сүхбаатар аймгийн хэмжээнд Анхилуун мухар цагааны тархац, нөөц

ID	Цэг	Эмийн мухарцагааны тархсан ой	Талбай, га	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
5	94	Үетэн-алаг өвст	560.7	0.2	112.0
Нийт, га			560.7		112.0

4.2.12. *Astragalus mongolicus* Bge.- Монгол хунчир



Зураг 43. *Astragalus mongolicus* Bge.

Статус: Эмийн ашигт ургамал.

Биологийн онцлог: Голлосон үндэстэй, 30-60 см өндөр, хар цагаан холилдсон үсэрхэг бадриун иштэй, өдлөг нийлмэл навчтай, навчинцар 10-18 хос, тонгоруу өндгөрхүү, доод талда үсрхэг. Цэцэг бойтгорхуу, шар өнгөтэй, сийрэгдүү баг цэцэгтэй.

Амьдралын хэлбэр: Олон наст өвслөг ургамал. **Монгол дахь**

тархалт: Хөвс., Ханг., Монг.-Даг., Монг.-Алт., Дунд. Халх., Их н., Олон н., Говь. – Алт. **Сүхбаатар аймаг дахь тархац:** Мөнххаан уул. **Ургах орчин:** Сайрын элстэй ёроол, чулуурхаг нураг, хад чулуу, сөөгөн ширэнгэнд ургана. **Ашигт чанар:** Мал тааруу иднэ. Үндэсийг нь Монгол уламжлалт эмнэлэгт хэрэглэнэ. **Сүхбаатар аймаг дахь тархац:** Мөнххаан сумын нийт **9183.35** га талбайд тархацтай.

Нөөц тооцсон дүн: Сүхбаатар аймгийн хэмжээнд зөвхөн Мөнххаан суманд Анхилуун мухар цагаан нийт **560.7 га талбайд 280.35** цн биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 64. Сүхбаатар аймгийн хэмжээнд Монгол хунчирын тархац, нөөц

ID	Цэг	Эмийн мухарцагааны тархсан ой	Талбай, га	Биологийн нөөц, ц/га	Нийт биологийн нөөц, ц
5	94	Үетэн-алаг өвст	560.7	0.5	280.35
Нийт, га			560.7		280.35